

**ЭМЭГТЭЙ ХОРИГДЛЫН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ,
ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ
/эргэлт, уулзалтын жишээ нь дээр/**



Г.ХОСБАЯР

Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах
багш, хошууч

А.ХАЛИУН

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
531 дүгээр дамжааны сонсогч*

Товч агуулга: Илтгэлд хоригдлын эрх гэж юу болох, эмэгтэй хоригдлын эрх зүйн байдал, хорих ял эдлүүлэх ажиллагааны онцлог, мөн хэрэгжилтийн талаар, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар судлаачдын байр суурийг илэрхийлсэн.

Түлхүүр үг: Хүний эрх, эрх чөлөө, хоригдол, эмэгтэй хоригдол, эрх зүйн байдал, хорих ял эдлүүлэх ажиллагаа, дэглэм, зэрэглэл зэрэг.

Оршил:

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн баталсан билээ. Нийгэм, эдийн засгийн болон амьдралын хэв маягийн өөрчлөлттэй уялдан Монголын нийгмийн амьдралд эерэг, сөрөг олон шинэ үзэгдэл бий болж үүнтэй холбоотойгоор гэмт хэрэг үйлдэж байгаа нөхцөл байдал, арга хэрэгсэл, хэв маягт ч өөрчлөлт гарсан.

Хорих ял бол гэмт хэргийн салшгүй хэсэг бөгөөд хууль зөрчигчдийг цээрлүүлэх гэхээс илүү тэднийг нийгмээс тусгаарлаж тэдний зүгээс дахин нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, дахин нийгэмшүүлэх явдал юм.

Тийм ч учраас хүн төрөлхтөн буруу, зөв үйлдлийг ялгаж салгадаг болсон үеэс эхлээд тухайн үйлдэл, эс үйлдлийг ямар аюултай болохыг өөрсдийн үнэлэмжээр тогтоож, түүнд тохирсон шийтгэлийг бий болгож хэрэглэсээр ирсэн.

Эмэгтэй хоригдлын эрх зүйн байдал, тулгамдаж буй зарим асуудал гэсэн сэдвийн хүрээнд хоригдлын эрх, эрх зүйн байдал гэсэн ойлголт мөн адил эмэгтэй хоригдлын ял эдлүүлэх ажиллагаа, эрх зүйн байдалтай шууд холбогдох ба эрэгтэй хоригдлоос ялгагдах тал, эрх зүйн байдлыг харьцуулан судлахыг зорилоо.

Үндсэн хэсэг:

“Хүний эрх” гэдэг ойлголт нь товчхондоо хүн болж төрсний хувьд заяагдсан, ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран эдэлвэл зохих эрх, эрх чөлөөг хэлдэг. Хүний эрх нь хүний нэр төртэй, үнэ цэнэтэй амьдрах наад захын хэрэгцээ шаардлага, оршихуйн үндэс юм.¹

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын нэгдүгээр зүйлд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд ахан дүүсийн ёсоор харилцах ёстой” гэж тунхаглажээ.

Босанкует нь ‘Эрх’ гэдэг бол нийгмээс хүлээн зөвшөөрч төрөөс баталгаажуулсан иргэний шаардлага гэжээ.

Хүний эрх гэдэг гэдэг нь товчхондоо хүн болж төрсний хувьд заяагдсан ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран эдэлвэл зохих, эрх чөлөөг хүний эрх гэнэ. Мөн өөрөөр хэлбэл хүний эрх нь хүний зэрэгтэй үнэ цэнэтэй амьдаралын наад захын баталгаа юм.

Хүний эрх нь жам ёсны шинжтэй бөгөөд хүний эдлэх эрхийг, төрөөс эсвэл хэн нэгэн хүнээс өгдөггүй, харин хууль зүйн хэм хэмжээгээр баталгаажуулж өгдөг. Хүний эрхийг үндэсний аюулгүй байдал, нийгмийн ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор хязгаарлаж болно. Гэхдээ энэ хязгаарлалт нь зөвхөн хуулиар зохицуулагдсан байх ёстой гэж үзвэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл

¹ Хүний эрхийн дээд комиссарын газар. Хүний эрх ба хорих байгууллага. /орчуулсан Б.Эрдэнэбаяр/. УБ., 2004 он. 7 дахь тал

бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг хорих ял гэнэ”² гэж заасан байна.

Эрх зүйн байдал гэж /лат. *Status*, англ. *Legal status*, ор. *Правовой статус*/ - эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон субъектын эрх ба үүргийн нийлбэр цогц.

Е.А.Антонян - Иргэний эрх зүйн байдал дээр тулгуурласан эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон эрүүгийн ял эдлүүлэх хугацаанд дахь тухай этгээдийн эрх зүйн байдлыг хэлнэ.

Н.А.Стручков - Эрүүгийн ял эдлүүлэх хугацаанд хоригдсон этгээдэд өгөгдсөн үүрэг, эрхийн нийлбэр цогц юм.

М.И.Федоров - Иргэний болон тусгай үүрэг, эрхийн нийлбэр цогц юм.

С.И.Селиверстов - Эрх, хууль ёсны ашиг сонирхол болон үүргүүдийн нийлбэр цогц гэж тус тус тодорхойлжээ.

Тэгвэл хоригдлын эрх гэж юу вэ? гэсэн асуулт урган гарч ирж байгаа юм. Улмаар хоригдлын эрхийн талаар эрдэмтэн судлаачдын томьёололоос авч үзвэл: Монгол Улсын Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн салбарын судлаачид хоригдлын эрх зүйн байдлын талаар өөрсдийн бүтээлдээ тухайлбал, академич С.Нарангэрэл хоригдлын эрхийн байдлыг “тухайн этгээдийн ял эдлэх явцдаа эдлэх эрх, хүлээх үүргийн цогцолбор юм” гэж тодорхойлсон бол, доктор /Ph.D/, профессор А.Лхагва “Хорих ял эдлүүлэх дэглэмийн онцлогт тохирсон эрх эдэлж, үүрэг хүлээхийг хоригдлын эрхийн байдал гэнэ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, түүний агуулгад нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн заалтаар баталгаажин хэрэгжинэ”³ хэмээн тодорхойлсон байна.

Хоригдогчдын эрхийн түгээмэл шинжүүдийн уламжлалыг авч үзвэл: Хүний эдлэх эрх, эрх чөлөө, хүлээх үүрэг, тэдгээрийн хууль тогтоомжийн харилцан зохицуулалт-шүтэлцээний тухай ярихад хүрвэл энэ нь маш өргөн хүрээтэй асуудал юм. Иймд хоригдлын эрхийн байдал буюу эрх, үүргийг МУ-ын Үндсэн хуулийн иргэний эрх, эрх чөлөөтэй холбогдсон нийтлэг заалт, түүнчлэн ШШГТХууль, бусад хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг хооронд нь харьцуулан авч үзвэл илүү тодорхой болно.

Хоригдлын эрхийг хангах, хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалтыг хууль зүйн хүчин чадал, үйлчлэх хүрээгээр нь бүлэглэн авч үзвэл:

² Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл., 2016 он. №07

³ Х.Пүрэвсүрэн. Хүний эрх: хорих ял эдлэгсэдийн эрхийн байдал. УБ., 2010 он. 26 дахь тал

1.Хүний эрх түүн дотроо хорих ял эдлүүлэх талаарх Нэгдсэн үндэстний байгууллагаас гаргасан хэм хэмжээ;

2.Монгол Улсын Үндсэн хууль;

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар;

4.Монгол Улсын бусад хууль тогтоомж /иргэний хууль, эрүүгийн хууль, хөдөлмөрийн тухай хууль, тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль/ зэрэг болно.

Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд /1955 онд/, Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмууд /1988 онд/, Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмуудад /1990 онд/ хоригдож буй болон цагдан хоригдож буй хүмүүсийн эрхийг хамгаалах зарчмын хэм хэмжээг баталгаажуулсан бөгөөд нэгдэн орсон гишүүн улс орнууд дагаж мөрдөх, үндэсний хууль тогтоомжиндоо тусгах үүргийг хүлээдэг.

Дээрх баримт бичгүүд нь аливаа хорих газрын дэглэмийг зохион байгуулах үндсийг бий болгодог ба хоригдлууд болон цагдан хоригдож буй хүмүүстэй харьцах, сахилга дэг журам, гадаад ертөнцтэй харьцах, эрүүл мэнд, ангилалт, тусгаарлалт, бүртгэх, гомдол гаргах, ажил хөдөлмөр, амралт, шашин шүтлэг, эргэлт уулзалт, соёл боловсрол зэрэг бүх талын асуудлыг хамаардаг.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолоор “Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм” -ийг шинэчлэн батлагдсаны дагуу Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар хаалттай 7, нээлттэй 9, нээлттэй, хаалттай дэглэмтэй 3 хорих анги, сургалтхүмүүжлийн тусгай байгууллага 1, эмнэлэг 2, эмэгтэйчүүдийн хорих анги 1, нийт 23 хорих анги, Нийслэлд Цагдан хорих төв 1, орон нутагт 25 цагдан хорих байртайгаар хуульд заасан тусгай чиг үүргийн үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид өнөөгийн байдлаар хоёр зуун хорь гаруй эмэгтэй хоригдол ял эдэлж байна. Хорих ял эдлүүлэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулдаг. Эмэгтэй хоригдол нь эрэгтэй хоригдлоос дэглэм, зэрэглэл шагналын хоног, эргэлт

уулзалт, мөн хорих ял эдэлж байх хугацаандаа хүүхэд төрүүлсэн хоригдлыг хамт байлгаж болгодог зэрэг эрх зүйн зохицуулалтаар ялгаатай, эрх зүйн байдлаар онцлог талуудтай.

Хэдийгээр Монгол улсын Үндсэн хуульд хэнийг ч дур мэдэн баривчлан хорьж, эрх, эрх чөлөөнд нь халдаж, албадан ажиллуулж болохгүй тухай заасан боловч гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдийг олон нийтээс тусгаарлаж эрх, эрх чөлөөнд нь хуульд заасан хязгаарлалт тогтоох шаардлагатай болдог.

Хорих ял оноосон шүүхийн шийтгэх тогтоолыг хэрэгжүүлэх нь төрийн албадлагын онцгой ажиллагаа юм. Хорих ял шийтгүүлсэн этгээдийг тэдний гэмт хэрэг, эдлэх ялын хугацаа зэргийг харгалзан дэглэмийн харилцан адилгүй нөхцөлд ялыг нь эдлүүлдэг. Эмэгтэй хоригдлын хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэл мөн адил үүнд хамаарна.

Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлалыг судлан авч үзэхэд эрүүгийн ялын бодлого нь гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдэд энэрэнгүй хандах чиг хандлагыг баримталж ирсэн байна.

Жишээлбэл, цаазаар авах ялыг 1929 оны Шүүх цаазын бичиг, 1934 оны шүүх цаазын бичиг, 1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулиар жирэмсэн буюу хөхүүл, хүүхэдтэй эмэгтэйд цаазаар авах л оногдуулахыг хоригложээ. Харин 1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулиас эмэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулахыг бүр мөсөн хориглосон байна.⁴

Манай улсад анх 1974 онд хорих ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн дагнан хорих ангийг байгуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийг ханган ажиллаж ирсэн.

Хорих ял нь бусад төрлийн ялаас хамгийн хатуу, хүнд хэлбэрийг өөртөө агуулдаг учраас бусад төрлийн ялаар ялын зорилгод хүрч чадахгүй. Тийм нөхцөлд л хорих ялыг биечлэн эдлүүлэх учиртай. Нөгөө талаар эмэгтэйчүүд хүнд ноцтой гэмт хэрэг үйлдэж байгаа нь хорих ялыг шүүхээс биечлэн эдлүүлэхээс өөр аргагүй юм. Мөн нэгэн судалгаанаас үзэхэд хүнийг санаатайгаар алах, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, залилан мэхлэх зэрэг гэмт хэргийг ихэвчлэн эмэгтэйчүүд үйлдэж байна.

⁴ Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/ 2011 422 дахь тал

Одоо тус хорих ангид хорих ял эдэлж буй хоригдлуудын 49 хувь нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн, 25 хувь нь хүний амь биед халдсан гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүд байгаа нь нийт хоригдлуудын 74 хувийг эдэлж байгаа юм.

№	2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /эмэгтэй хоригдлын/	2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /эрэгтэй хохирлын/	2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /эмэгтэй хохирлын/	Тайлбар
1	111.1. Эмэгтэй ялтны ялыг зөвхөн эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлнэ.		202.1.Хорих ял шийтгүүлсэн арван найман насанд хүрсэн эмэгтэй хоригдлын ялыг эмэгтэйчүүдийн нээлттэй, хаалттай хорих ангид эдлүүлнэ.	
2	111.2. Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна.			
3	111.3. Эмэгтэй ялтан илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй бөгөөд удаан хугацааны уулзалтыг жилд найман удаа хийж болно.	198.3.Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болох бөгөөд түр хугацааны уулзалт хийх, захидал илгээх, илгээмж авах, утсаар ярих тоог хязгаарлахгүй . 198.4.Нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа	202.3. Хоригдлын илгээмж авах тоог хязгаарлахгүй бөгөөд 7 хоногт нэг удаа түр, 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 7 хоногт нэг удаа илгээмж явуулж, утсаар ярьж болно.	Эмэгтэй хоригдлын эргэлт уулзалт хийх, илгээмж авах тоог 2002 оны ШШГТХ-тай харьцуулахад түр болон илгээмжийн тоог хязгаарладаггүй байсан. Харин удаа хугацааны уулзалтыг жилд 8 удаа хийж болох зохицуулалттай байв. Харин нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа эрэгтэй хоригдлын эргэлт, уулзалт, илгээмж, утсаар ярих тоотой харьцуулвал эмэгтэй

		хоригдол 7 хоногт нэг удаа түр, 45 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 7 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болох бөгөөд захидал илгээх тоог хязгаарлахгүй.		хоригдлын эрх зүйн байдал дордуулсан гэх үндэслэлтэй байна. Учир нь нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа эрэгтэй хоригдлын түр хугацааны уулзалт хийх, захидал илгээх, илгээмж авах, утсаар ярих тоог хязгаарлахгүй байхаар хуульчлагдсан бол эмэгтэй хоригдлын 7 хоногт нэг удаа илгээмж явуулж, утсаар ярьж болохоор хуульчлагдсан байна.
4	111.4. Эмэгтэй ялтан чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол 1 сард нэг удаа түр, 2 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 1 сард нэг удаа илгээмж авч болно.	199.4.Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол нь 60 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно.	202.4.Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд...Хоригдол 30 хоногт нэг удаа түр, 60 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа утсаар ярьж, 15 хоногт нэг удаа илгээмж авч болно.	
5		199.5.Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 90 хоногт нэг удаа түр, 120 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 60 хоногт нэг удаа	202.5.Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд... Хоригдол 45 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, 60	

		илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно.	хоногт нэг удаа утсаар ярьж болно.	
6	111.5. Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно.		202.8.Хорих анги нь эхийн хамт байгаа хоёр хүртэлх насны хүүхдийг эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинг бүрдүүлсэн тусгай байр, нөхцөлөөр хангана.	
7	111.6. Энэ хуулийн 111.5-д заасны дагуу хорих анги нь эхийн хамт байгаа 0-1 насны хүүхдийг эрүүл мэнд өсөж бойжих, аюулгүй орчинг бүрдүүлсэн тусгай байр, нөхцөлөөр хангана.		202.8.Хорих анги нь эхийн хамт байгаа хоёр хүртэлх насны хүүхдийг эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинг бүрдүүлсэн тусгай байр, нөхцөлөөр хангана.	

Хорих анги	Зэрэглэл	Түр хугацааны уулзалт	Удаан хугацааны уулзалт	Илгээмж авах	Утсаар ярих	Захидал илгээх
Нээлттэй	Энгийн	∞	30 хоногт 1 удаа	∞	∞	∞
	Тусгай	7 хоногт 1 удаа	45 хоногт 1 удаа	7 хоногт 1 удаа	7 хоногт 1 удаа	∞
Хаалттай	Энгийн	60 хоногт 1 удаа	90 хоногт 1 удаа	30 хоногт 1 удаа	30 хоногт 1 удаа	0
	Тусгай	90 хоногт 1 удаа	120 хоногт 1 удаа	60 хоногт 1 удаа	60 хоногт 1 удаа	0

	Тусгай нэгж	180 хоногт 2 удаа	0	90 хоногт 1 удаа	0	90 хоногт 1 удаа
--	----------------	----------------------	---	------------------------	---	---------------------

Эмэгтэйчүүдийн Хорих анги	Зэрэглэл	Түр хугацааны уулзалт	Удаан хугацааны уулзалт	Илгээмж авах	Утсаар ярих
Нээлттэй		7 хоногт 1 удаа	30 хоногт 1 удаа	7 хоногт 1 удаа	7 хоногт 1 удаа
Хаалттай	Энгийн	30 хоногт 1 удаа	60 хоногт 1 удаа	15 хоногт 1 удаа	30 хоногт 1 удаа
	Тусгай	45 хоногт 1 удаа	90 хоногт 1 удаа	30 хоногт 1 удаа	60 хоногт 1 удаа
Ял эдэлж байх хугацаандаа хүүхэд гаргасан хоригдол				∞	

Дээрх хуулийн зохицуулалтаас харахад нээлттэй хорих ангид хорих ял эдэлж байгаа эмэгтэй хоригдлын эрх зүйн байдлыг дордуулж хуульчилсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Мөн эмэгтэй хоригдолд эрэгтэй хоригдлоос яалгагдах онцлог гэж болох нэгэн шинж байдаг. Энэ нь “Хоригдол ээж” гэдэг ойлголт юм. 0-2 хүртэл насны хүүхэд хорих ангийн дэргэд ээжтэйгээ хамт өсөн торинож байгаа хүүхэд гэсэн агуулгаар анхаарал халамж тавих шаардлагатай.

Гэвч хүүхэдтэй хоригдол эмэгтэйчүүдийн ялыг хууль журмын дагуу эдлүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Мөн хоригдол эмэгтэйчүүдийн дунд явуулах нийгмийн ажлын гол чухал зорилт бол хувь хүний тухайд өндөх агуулга бүхий нийгмийн чухал үнэт зүйл болох эх хүний сэтгэлийг хадгалж үлдээхэд оршдог.

Олон улсын орнуудын практикаас харьцуулалт хийж үзэхэд Канад улсад эмэгтэй хоригдол 5 хүртэлх насны хүүхэдтэйгээ хамт хорих ангид байж болдог бол Австрали улсад эмэгтэй хоригдол нь 4 хүртэлх насны хүүхэдтэйгээ хамт хорих ялаа эдэлж болдог хуулийн зохицуулалттай.

Хууль зүйн үндэсний төв, ШШГЕГ, УЕП-аас явуулсан судалгаагаар хорих ялаар шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн ар гэрт ямар өөрчлөлт гарсныг судлахад /давхардсан тоогоор/

- 58 ялтан буюу 48.7 хувь нь тэднээс найз нөхөд нь нүүр буруулсан
- 55 ялтан буюу 46.2 хувь нь ах дүү хамаатан садны хүмүүс нүүр буруулсан,
- 43 ялтан буюу 36.1 хувь нь орон гэрээ алдсан, 42 ялтан буюу 35.3 хувь нь гэр бүл салсан,
- 33 ялтан буюу 27.7 хувь нь хүүхэд сургуулиас завсардсан, 33 ялтан буюу 27.7 хувь нь эд хөрөнгөө алдсан,
- 28 ялтан буюу 23.5 хувь нь гэр бүлийн хэн нэг нь нас барсан, 20 ялтан буюу 16.8 хувь нь хүүхэд гэр оронгүй тэнэмэл амьдралтай болсон гэж хариулжээ⁵.

Иймд ял эдэлж байгаа эмэгтэйчүүдийн хувьд харилцааны чадвар, тунгаан бодох чадвар, зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх чадвар, бусадтай холбоо тогтоох чадвар, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх чадвар сайжруулах сургалт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нэн шаардлагатай байгаа юм.

Дүгнэлт

2015 оны Эрүүгийн хууль батлагдаад 5 жил, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль батлагдаад 3 жилийн хугацаа өнгөрөөд байгаа бөгөөд энэ хугацаанд улсын хэмжээнд 4500 гаруй хоригдол, үүний дотор 250 гаруй эмэгтэй хоригдол ял эдэлж, хоригдлын тоо хурдацтай өсөж байна.

Эмэгтэйчүүдийн гэж нэрлэгддэг 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид өнөөдрийн байдлаар 248 хоригдол байгаа бөгөөд нээлттэй дэглэмд 214, хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд 23, хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 8, насанд хүрээгүй өсвөр насны 3 хоригдол ял эдэлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 202.2-д “Эмэгтэйчүүдийн хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна”, 202.3-д “Хоригдлын илгээмж авах тоог хязгаарлахгүй бөгөөд 7 хоногт нэг удаа түр, 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 7 хоногт нэг удаа илгээмж явуулж, утсаар ярьж болно” гэж хуульчилжээ.

⁵ <http://nli.gov.mn/pdf>

Харин нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа эрэгтэй хоригдлын эргэлт, уулзалт, илгээмж, утсаар ярих тоотой харьцуулвал эмэгтэй хоригдлын эрх зүйн байдал дордуулсан гэх үндэслэлтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198.3-д “Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болох бөгөөд түр хугацааны уулзалт хийх, захидал илгээх, илгээмж авах, утсаар ярих тоог хязгаарлахгүй” гэж заасан бол эмэгтэй хоригдол 7 хоногт нэг удаа илгээмж явуулж, утсаар ярьж болохоор хуульчлагдсан байна.

Иймд хорих ял эдлүүлэх ажиллагаанд эмэгтэй хоригдлын эргэлт уулзалттай холбоотой дараах зохицуулалт, практикийг бий болгохыг санал болгож байна. Энэ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд холбогдох саналыг хүргүүлэх.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 202.3-д заасан эргэлт, уулзалт, захидал, илгээмжийн тоог мөн хуулийн 198.3-д заасантай ижил түвшинд эрх зүйн байдлыг дээрдүүлж хуульчлах.

3. Эргэлт холбоотой гадаадын орнуудын эрх зүйн зохицуулалт, практикийг судлан дэвшилтэд хэм хэмжээ, жишгийг өөрийн орны нөхцөл байдалд нийцүүлэн нутагшуулан хэрэгжүүлэх хэмжээг авах шаардлагатай.

Эх сурвалжийн жагсаалт

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2002 он/
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017 он/
3. Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл., 2016 он. №07
4. Хүний эрхийн дээд комиссарын газар. Хүний эрх ба хорих байгууллага. /орчуулсан Б.Эрдэнэбаяр/. УБ., 2004 он.
5. Х.Пүрэвсүрэн. Хүний эрх: хорих ял эдлэгсэдийн эрхийн байдал. УБ., 2010 он.
6. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/ 2011 он
7. <http://nli.gov.mn/pdf>
8. www.parliament.mn
9. <https://www.legalinfo.mn/>

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ



Г.ХОСБАЯР

Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах
багш, хошууч

Товч агуулга: Илтгэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн хөгжил, хорих ял эдлүүлэх ажиллагааны уламжлал, эрх зүйн шинэчлэлийн талаар үечлэн авч үзэж, судлаачийн зарим дүгнэлт, саналыг илэрхийлсэн.

Abstract: The researcher identifies needs, rationales and issues with respect to the use firearms, special weapons and force by officers from the Court Decision Execution Authority and government authorities with special mandates and takes into account challenges faced.

Түлхүүр үг: Хорих ял эдлүүлэх ажиллагаа, түүхэн уламжлал, эрх зүйн шинэчлэл.

Key words: Imprisonment processes and historical tradition, and transformation of legal framework.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 1921 оны 07 дугаар сарын 10-нд Шүүх яамны ерөнхий хэлтсийн харьяанд “Гяндан салаа” нэртэйгээ байгуулагдсанаас хойш эдүүгээ 100 жил болж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага байгуулагдсан цагаасаа эхлэн шүүхийн шийдвэрээр төрийн онцгой албадлагыг хэрэгжүүлж, цагдан хорих, хорих ял шийтгүүлсэн этгээдийн хорих ялыг эдлүүлэх, нийгэмшүүлэх, зан үйлд нөлөөллийн арга хэмжээ авах, хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн чиг баримжаа олгох, ард иргэдийнхээ амгалан тайван байдлыг хамгаалах, хоригдлуудын дундаас гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэн, захиргаа, зөрчлийн болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд заасан үндэслэл журмын дагуу олон улсын гэрээ конвенцид заасны дагуу хүний эрх, эрх чөлөөг хамгаалах,